



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/101


Бор-Өндөр сум

**Замын хөдөлгөөнийг хэсэгчлэн
зогсоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, Зам хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх нийтийн марафон гүйлт 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулагдах тул баталсан маршрутын дагуу тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 18:00–19:00 цагийн хооронд хязгаарлаж ажиллахыг Бор-Өндөр сумын Сум дундын Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа (Т.Энхбаяр)-д, тамирчдын эрүүл мэндэд хяналт тавьж ажиллахыг Нэгдсэн эмнэлгийн дарга (А.Батбаатар)-д тус тус даалгасугай.
2. Тээврийн хэрэгслийг хязгаарлах замын маршрутыг хавсралтаар баталсугай.
3. Бүх нийтийн марафон гүйлтэнд албан хаагчдаа идэвхтэй оролцуулахыг албан байгууллага, аж ахуй нэгжийн дарга эрхлэгч нарт, багийн иргэдийг идэвхитэй хамруулахыг багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.
4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Галбадрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ

Засаг даргын 2024 оны
06 дугаар сарын 07-ны өдрийн
А/101 дүгээр захирамжийн хавсралт

